



## НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 1169


Улаанбаатар хот

### Нийслэл, дүүргийн оны тэргүүний Биеийн тамирын хамтлаг шалгаруулах тухай

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хуулийн 10 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтыг хэрэгжүүлэх, Нийслэлийн засаг даргын 2006 оны 165 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэл, дүүргийн Нутгийн захиргааны байгууллагуудын дэргэдэх Биеийн тамирын хамтлагуудын үйл ажиллагааны тайлан үр дүнг үндэслэн Нийслэл, дүүргийн 2016 оны тэргүүний биеийн тамирын хамтлагуудыг шалгаруулсугай.
2. Нийслэл, дүүргийн 2016 оны тэргүүний биеийн тамирын хамтлагуудын шагналын төсвийг хавсралтаар баталсугай.
3. Шагналд шаардагдах 4.240.000 /дөрвөн сая хоёр зуун дөчин мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны биеийн тамир, чийрэгжүүлэлтийн нийтийг хамарсан арга хэмжээний төсвөөс гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.
4. Шалгаруулалтын арга хэмжээг зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500136

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын  
хорооны даргын 2016 оны 11 дугаар  
сарын 27-ны өдрийн 11 дугаар тушаалын хавсралт



Нийслэл, дүүргийн 2016 оны тэргүүний Биеийн  
тамирын хамтлаг шалгаруулах төсөв

№	Зардлын нэр	Шагнал /төг/	Дүн /төг/
1.	Дүүргүүдийн Биеийн тамир, спортын хороод	1-р байр	800.000
		2-р байр	700.000
		3-р байр	1.800.000
2.	Цом, өргөмжлөл	640.000	640.000
3.	Анонс, урилга, бичлэг	300.000	300.000
<b>ДҮН:</b>		<b>4.240.000</b>	<b>4.240.000</b>

Боловсруулсан  
Хянасан

А.Болдмаа  
О.Эрдэнэцэцэг